

**УДИРДАХ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛЫН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2014-01-02

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.11, Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10, 8.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батласан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 8.1, 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэлтэс, тасгийн дарга, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагч, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын даргын албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, зарыг алба хаагчдад хүргэж байна.

**ТУСГАЙ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Алба, нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Цолны зэрэглэл	Цалингийн зэрэглэл
Хэлтсийн дарга				
1	Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар	Нэгдүгээр хэлтсийн дарга	Цагдаагийн хурандаа	ТТ-3
Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тасгийн дарга				
2	Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газар	Шуурхай удирдлагын тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
3	Баянхонгор аймгийн цагдаагийн газар	Замын цагдаагийн тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
4	Говь-Алтай аймгийн цагдаагийн газар	Захиргааны удирдлагын тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
5	Дорнод аймгийн цагдаагийн газар	Мөрдөн байцаах тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-4
6	Өмнөговь аймгийн цагдаагийн газар	Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
7	Төв аймгийн цагдаагийн газар	Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
8	Хэнтий аймгийн цагдаагийн газар	Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
Дотоодын цэргийн штаб				
9	Дотоодын цэргийн 05 дугаар анги	Ангийн захирагч	Хурандаа	ТТ-2
10	Дотоодын цэргийн 05 дугаар анги	Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Хурандаа	ТТ-3

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг.Дараах болзол, шаардлагыг хангасан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагч шалгалтад бүртгүүлнэ. Үүнд:

1.1.ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ:

Боловсрол	Дээд боловсролтой, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- Менежмент ба удирдахуй /0413/ -Цэрэг, батлан хамгаалах /1031/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/ -Аюулгүй байдлыг хангахад ангилагдаагүй чиглэл /1039/ -Эрх зүй /042101/ -Олон улсын эрх зүй /042102/
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх /2021, 2022, 2023 оны “Албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-ийн “газрын дарга”-ын нөөцөд бүртгэгдсэн ба 2022, 2023 оны нөөцөд бүртгэгдсэн бол албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх/
Туршлага	Төрийн тусгай албанд 12-оос доошгүй жил, үүнээс хэлтсийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.
Бусад	Ял, сахилгын шийтгэлгүй байх Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварын шаардлагыг хангаж байх

1.2.ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧИЙН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ, ШТАБЫН ДАРГА

Боловсрол	Дээд боловсролтой, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- Менежмент ба удирдахуй /0413/ -Цэрэг, батлан хамгаалах /1031/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/ -Аюулгүй байдлыг хангахад ангилагдаагүй чиглэл /1039/ -Эрх зүй /042101/ -Олон улсын эрх зүй /042102/
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх /2021, 2022, 2023 оны “Албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-ийн “хэлтсийн дарга”-ын нөөцөд бүртгэгдсэн ба 2022, 2023 оны нөөцөд бүртгэгдсэн бол албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх/
Туршлага	Төрийн тусгай албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах офицер /штаб 2, анги 3/ түүнтэй адилтгах албан тушаалд ажилласан байх.
Бусад	Ял, сахилгын шийтгэлгүй байх Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварын шаардлагыг хангаж байх

1.3. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН НЭГДҮГЭЭР ХЭЛТСИЙН ДАРГА

Боловсрол	Дээд боловсролтой, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Менежмент ба удирдахуй /0413/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/ -Аюулгүй байдлыг хангах /103901, 103912/
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх /2021, 2022, 2023 оны “Албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-ийн “хэлтсийн дарга”-ын нөөцөд бүртгэгдсэн ба 2022, 2023 оны нөөцөд бүртгэгдсэн бол албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх/
Туршлага	Цагдаагийн байгууллагад 12-оос доошгүй жил ажилласан үүнээс чиглэлийн ахлах, хэсэг, тасгийн даргын болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй байх.
Бусад	Ял, сахилгын шийтгэлгүй байх
	Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварын шаардлагыг хангаж байх

1.4.НУТАГ ДЭВСГЭР ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАСГИЙН ДАРГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, -Аюулгүй байдлыг хангахад ангилагдаагүй чиглэл /1039/, -Эрх зүй /042101/,
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх /2021, 2022, 2023 оны “Албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-ийн “нэгжийн тасгийн дарга”-ын нөөцөд бүртгэгдсэн ба 2022, 2023 оны нөөцөд бүртгэгдсэн бол албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх/
Туршлага	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
Бусад	Ял, сахилгын шийтгэлгүй байх
	Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварын шаардлагыг хангаж байх

Хоёр. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

-Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт; /pdf/

-Оролцогчийн танилцуулга; /pdf/

-Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг; /pdf/

Тайлбар:

-Дээр дурдсан баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан алба хаагч өөрөө хариуцна.

-Хэрвээ хуурамч, дутуу баримт бичиг бүрдүүлэн төрийн албаны тусгай шалгалтад бүртгүүлсэн, оролцсон, нэр дэвшсэн, албан тушаалд томилогдсон нь тогтоогдсон нөхцөлд үүнээс үүдэн гарах хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.

-Шалгалт зохион байгуулах комисс шаардлагатай гэж үзвэл нэмэлт материал шаардах эрхтэй болохыг анхаарна уу.

-Дээрх бүрдүүлбэрийн дэс дарааллын дагуу файлуудаа нэгтгэн (pdf, rar, zip) 1 файл болгон энэхүү зард заасан цахим шууданд ирүүлнэ үү.

Гурав. Бүртгэлийн ажиллагаа

Сонгон шалгаруулалтын комисс албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийг зарласан албан тушаалын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрийн 15.00 цагийн хооронд /Олзбаяр.Б д/х ЦЕГ, ЗУГ, ХНХ, Соронзонтунгалаг.Ц д/х ДЦШ, ЗУГ, ХНЦТБХ outlook/ хаягаар цахимаар хүлээн авна.

Бүртгүүлэхээр ирүүлсэн алба хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрэн болон тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг комисс нягтлан шалгаад бүртгэх эсэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа хэлэлцэн гаргах ба бүртгээгүй бол энэ тухай шалтгааныг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

Холбоо барих утас: 70191095, 70191043